

**ХЭНТИЙ АЙМГИЙН ТӨВ ЧИНГИС ХОТОД БАРИГДАХ 30 ГКАЛ/Ц ХҮЧИН ЧАДАЛТАЙ
ДУЛААНЫ СТАНЦ, 10.916 М ШУГАМ ХООЛОЙ, 16 ТҮГЭЭХ ТӨВҮҮДИЙГ БАРЬЖ
АШИГЛАХ ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН	1
Агуулга	2
1. Төслийн үе шатны хэрэгжилтийн товч танилцуулга.....	3
2. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хүрээнд хийгдсэн ажлууд	4
2.1 Газрын гадарга, хэвлийд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр	4
2.2 Агаарын чанарт нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр	5
2.3 Гадаргын усанд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр.....	6
2.4 Газрын доорх усанд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр.....	6
2.5 Хөрсөн бүрхэвчид нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр	7
2.6 Ургамлан нөмрөгт нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр	8
2.7 Хог хаягдлын менежмент төлөвлөгөөний хүрээнд.....	8
3. Нөхөн сэргээлт, тохижуулалтын төвлөгөөний	8
4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний хүрээнд.....	9
5. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд.....	9
6. Осол эрсдэлийн төлөвлөгөөний менежментийн хүрээнд.....	9
7. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн ажлууд.....	10
7.1 Хөрсөн бүрхэвч	10
7.2 Ургамлан нөмрөг.....	11
8. Байгаль орчны менежмент төлөвлөгөөний нийт зардал	12
9. Дүгнэлт	13
10. Хавсралт	14

ТӨСЛИЙН ҮЕ ШАТНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Хэнтий аймгийн Чингис хотод баригдах 30 Гкал/ц хүчин чадалтай дулааны станц, 9.182 метр шугам хоолой, дулаан дамжуулах 16 төвийг барьж ашиглах төслийг “Хасу мегаватт” ХХК компани гүйцэтгэж байна.

Хэнтий аймгийн дулаан хангамжийг сайжруулах төслийн ажлын гүйцэтгэгч “Хасу мегаватт” ХХК нь төслийн талбайд 2023.05-н сард эхэлсэн бөгөөд өнгөрсөн хугацаанд доорх ажлуудыг гүйцэтгээд байна.

2023 оны 05-н сараас барилгын суурийн ажил, конвейер I, II, бутлуурын барилгын суурийн ажлууд эхэлсэн.

Конвейер I, II, бутлуурын барилга, харуулын байрны суурь, хучилтын ажил, түлш хүлээн авах барилга, утаа сорогчийн барилгын суурь, цахилгааны барилгын суурь зэрэг үндсэн барилга угсралтын ажил 21 хувийн гүйцэтгэлтэй байна.

2023 онд төслийн гүйцэтгэл Барилга угсралт 21 % Зураг төсөв 70 %

Тоног төхөөрөмж ханган нийлүүлэлт 60 % Нийт гүйцэтгэл 41 % тай явж байна.

2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд “Хасу мегаватт” ХХК-ийн зүгээс доорх үндсэн чиглэлийг голлон хэрэгжүүлэн ажиллалаа.

- Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хүрээнд
- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХҮРЭЭНД:

2018 онд батлагдсан 10 аймгийн төвийн дулаан хангамжийг сайжруулах төслийн техник эдийн засгийн үндэслэл, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, ерөнхий үнэлгээний дүгнэлтэд тулгуурлан байгаль орчны бүрдэл хэсгүүд бүрт тодорхойлсон сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх хугацаа, үндэслэл, баримтлан ажиллах дүрэм, стандартууд, зардлын хамт оруулсныг мөрдөж ажилласан.

НЭГ. ГАЗРЫН ГАДАРГА, ХЭВЛИЙД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР			
Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хэрэгжилтийн товч тодорхойлолт	Биелэлтийн хувь
Газрын гадарга бохирдох	Дулааны станцын барилгын ажлыг эхлүүлэхээс өмнө тус үнэлгээний тайлангийн хог хаягдлын хэсэгт заасны дагуу “Хог хаягдлыг дахин ашиглах, зайлуулах, устгах, төлөвлөгөө” боловсруулан үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах шаардлагатай. Дулааны станцын талбайн ойролцоо хог хаягдал түр хадгалах цэг байгуулан, хадгалах, төвлөрсөн хогийн цэг рүү тээвэрлүүлэх шаардлагатай.	Төслийн талбай, ажилтнуудын ахуйн байрнаас гарах хог хаягдлыг тухай бүрд нь түр хадгалах саванд хийж тогтсон хугацаанд төв хогийн цэг дээр зориулалтын дагуу хаяж, хогийг ойр орчимд тархахаас сэргийлэн орон нутгийн байгууллагатай хамтран ковшоор түрэн гадаргын бохирдлоос сэргийлэн ажилласан. 2023 оны 06 сарын 08-ны өдөр ОНТҮГ-тай хийсэн гэрээний дагуу хог хаягдлыг зориулалтын тээврийн хэрэгслээр төвлөрсөн хогийн цэгт хүргэн хаяж ажилласан.	100%
	Барилгын ажилд ашиглаж байгаа тээврийн хэрэгслүүдийг тогтсон нэг зогсоолд байрлуулах, тээврийн хэрэгслийн үзлэг оношлогоог тогтмол хийж байх, тос масло асарсан тохиолдолд хамгаалах, саармагжуулах арга хэмжээ авах	Төслийн талбайд автын зогсоол байгуулж, авто хэрэгслүүдийг зогсоолд байршуулж ШТМ асархаас урьдчилсан сэргийлж ажилласан. Төслийн талбайд авто хэрэгслүүдийн засвар үйлчилгээг хийхийг хориглон зориулалтын засвар үйлчилгээний газарт хийлгэж газрын гадарга, болон хөрсөн бүрхэвч ШТМ-аар бохирдохоос сэргийлж ажилласан.	100 %
ХОЁР.УУР АМЬСГАЛД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР			
Дулааны станцаас жилд дунджаар 90,127 тн СО ₂ ялгарснаар агаар мандал дахь хүлэмжийн хийн агууламжийг нэмэгдүүлэх	Бүрэн шаталттай, өндөр үр ашигтай зуух ашиглахаар төлөвлөсөн.	Дулааны станцын барилга угсралтын ажил 2025 онд ашиглалтанд орох учраас одоогоор хэрэгжүүлэх боломжгүй.	30 %
Дулааны станцыг барих, түүхий эдийг зөөвөрлөх үйл ажиллагаанаас тоосжилт үүсч, агаарын чанарт сөргөөр нөлөөлөх	Дулааны станцын барилгын ажлын үед үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор замуудад тухай бүр усалгаа хийж байх	Барилгын ажлын үед агаарын чанарт сөргөөр нөлөөлөх нөлөөлөл байхгүй. Барилгын талбайд ажиллаж байгаа машин механизмаас үүсэх тоосжилт үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор зориулалтын зам талбайгаар зорчиж байна.	100 %

Дулааны станцын барилгын ажлын үед болон ашиглалтын үед ашиглах техникүүдийн яндангаас агаар бохирдуулагч хий ялгарах	Ашиглаж байгаа техник хэрэгслүүдэд тогтсон хугацаанд хяналт хийх ба шаардлага хангахгүй байгаа төхөөрөмжүүдийг ашиглалтаас хасах	Төслийн талбайд ашиглаж байгаа техник хэрэгслүүд нь ашиглалтын шаардлага хангасан ба тээврийн хэрэгслийн үзлэг оношлогоонд бүрэн хамрагдан ажиллаж байна.	100 %
ГУРАВ. ГАДАРГЫН УСАНД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР			
Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хэрэгжилтийн товч тодорхойлолт	Биелэлтийн хувь
Тээврийн хэрэгслээс ШТМ асгарах, дулааны станцын яндан, нүүрсний агуулах, үнс хадгалах байгууламжаас үүссэн тоос, дэгдэмхий үнсээр хөрсөн бүрхэвч бохирдож, улмаар хур тунадас орсон үед үерийн усаар дамжин гадаргын усыг бохирдуулж болзошгүй	ШТМ асгарсан тохиолдолд тархахаас сэргийлж зориулалтын шингээгч материал (spill kit)-ыг тээврийн хэрэгслүүдэд болон бусад шаардлагатай газруудад бэлэн байлгах Газрын гадарга болон хөрсөн бүрхэвчинд авах арга хэмжээг хэрэгжүүлэх	Барилгын талбайд ШТМ асгарахаас сэргийлж төслийн талбайд техникийн засвар үйлчилгээ хийхгүй байх. ШТМ ашиглахгүй байнгын хяналт тавин ажиллаж байна.	100 %
Барилгын ажлын үед ашиглагдах техник тоног төхөөрөмжөөс алдагдсан шатах, тослох материал угаагдаж, хур борооны үерийн усаар, зөөгдөн хөрсөн бүрхэвч бохирдох, улмаар гадаргын болон газрын доорх усны чанар, найрлагад нөлөөлж болзошгүй	Үнс хадгалах байгууламж нь битүүмжлэл сайтай, үнсийг зориулалтын автоцистернд ачих технологитой байх	Үнс хадгалах байгууламж 2023 онд ашиглалтанд ороогүй.	40 %

ДӨРӨВ. ХӨРСӨН БҮРХЭВЧИД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР			
Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хэрэгжилтийн товч тодорхойлолт	Биелэлтийн хувь
Дулааны станц, дулаан дамжуулах шугам болон дулаан дамжуулах төвүүдийг барих явцад нийт 4.84 га талбайгаас нийт 4.1 тн ялзмагийн нөөц бүхий 12100 м ³ үржил шимт хөрс хуулагдаж, эвдэрнэ.	Барилгын ажил эхлэхийн өмнө эвдэгдэх талбайн шимт хөрсийг 0.3 метр зузаантайгаар хуулан авч дулааны станцын эзэмшил газарт шимт хөрсний овоолгын талбайд хадгална.	Дулааны станцын төслийн барилгын ажлуудын явцад 4 барилгын талбайгаас нийт 0.4тн ялзмагийн нөөц бүхий 3495м3 үржил шимт хөрсийг стандартын дагуу хуулан авч тусгай овоолгын талбайд хадгалан, нөхөн сэргээлтэд ашиглахаар төлөвлөн ажиллаж байна.	100 %
ТАВ. УРГАМЛАН НӨМРӨГТ НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР			
Дулааны станц, нүүрс хадгалах байгууламж, харуулын байр зэргийг байгуулахад 0.43 га, дулаан дамжуулах 16 төвийг барихад 0.048 га, дулаан дамжуулах 10,916 метр (4 м өргөн) шугам хоолойг суурилуулахад 4.37 га буюу нийт 4.84 га талбайн ургамлан нөмрөг хөрсөн бүрхэвчийн хамт хуулагдаж, барилгажилт явагдаж буй талбай орчмын ургамлан нөмрөг талхлагдаж, тоосжилтонд өртөнө	Барилгажилтын нөлөөгөөр талхлагдсан газрыг тэгшилж, дулааны станцын барилга хоорондын талбайг тохижуулан, ургамал ургах нөхцөлийг бүрдүүлэхээс гадна явган хүний зам болон автозамыг хатуу хучилттай болгох.	2025 онд дулааны станцын барилгын ажил дууссан үед барилга хооронд, зам талбайг хатуу хучилттай болгох, ногоон байгууламж байгуулах, нөхөн сэргээх ажил хийгдэнэ.	0 %
ЗУРГАА. АМЬТНЫ АЙМАГТ НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР			
Барилгажилтын үе: Жижиг хөхтөн амьтад, тэдгээрийн нүх, оромж нөлөөлөлд өртөж болзошгүй.	Барилгажилтын явцад амьтад устахаас урьдчилан сэргийлж, газар хөндөлтийн өмнө амьтад өртөх эсэхийг шалгах, амьтдыг эрсдэх орчноос үргээж холдуулах,	Биологийн төрөл зүйлийн чухал амьдрах орчны хувьд дулаан хангамжийг сайжруулах төслийн талбай аймгийн хамгаалалттай Хэрлэн голын Б хэсгээс 400 м зайд, сумын хамгаалалттай Зүрхийн нуураас 17.6 км, Дэлийн бүрдээс 21.8 км, Улаан хад нэртэй газраас 28.7 км зайд буюу давхцалгүй. Мөн ойр байрлах (0-20 км) улсын ТХГН, ШЧГ, ойн сан байхгүй тул барилгажилт, ашиглалтын үед эдгээр газрын биологийн төрөл зүйлд үзүүлэх нөлөөлөл байхгүй.	100 %

ДОЛОО. ФИЗИК БОХИРДОЛ, ДУУ ШУУГИАНААС ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР			
Барилгын ажлын үйл ажиллагаанд ашиглагдах машин техник, тоног төхөөрөмжүүдээс дуу шуугиан үүсч, төслийн ажилчдын эрүүл мэндэд нөлөөлж болзошгүй	Үйл ажиллагааны явцад ашиглагдах техник хэрэгслүүдээс гарах дуу шуугианы түвшинг тухайн техник хэрэгслийн үйлдвэрээс зааж өгсөн дуу шуугианы техникийн үзүүлэлтээс хэтрүүлэхгүй байх,	Барилгын ажилд ашиглаж байгаа техник хэрэгслүүд нь стандарт дуу шуугианы техникийн үзүүлэлтээс хэтрээгүй.	100 %
Дулаан хангамжийн үйлчилгээ үзүүлж буй компаниудад ажиллаж буй ажилчид ажилгүй болох	Ажилгүй болох хүмүүсийг зохих сургалтад хамрагдуулж шинээр баригдах дулааны станцад ажиллуулах; Өөр ажлын байранд зуучлах, дэмжлэг үзүүлэхэд анхаарах	Орон нутгийн иргэдийг мэргэшүүлэх, ажлын байраар хангах ажлыг үе шаттай төлөвлөн ажиллаж байна.	80 %
НАЙМ. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ			
Ахуйн хатуу хог хаягдлаар бохирдох	Хог хаягдлыг ангилан ялгаж, шаардлага хангасан хогийн цэг байгуулан түр хадгалах	Төслийн талбайд ахуйн хог хаягдал хадгалах түр хогийн цэг байгуулан ажиллаж байна.	100 %
БОМТ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ			
Харьяа сумын ЗДТГ, БО-ны албанд	Орон нутгийн иргэдийн төлөөлөлийг дулааны станцын талбайд хүлээн авч, Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг танилцуулах,	Хэрлэн сумын Засаг дарга болон сумын Байгаль орчин хариуцсан албан хаагчидтай төслийн үйл ажиллагааг танилцуулах цаашид Байгаль орчны чиглэлээр хэрхэн хамтарч ажиллах талаар уулзалт зохион байгуулж ажилласан.	100 %

Газрын гадарга, хэвлийд нөлөөлөх сөрөг нөлөөллийг буруулах чиглэлээр

Төслийн талбай, ажилтнуудын ахуйн байрнаас гарах хог хаягдлыг тухай бүрд нь түр хадгалах саванд хийж тогтсон хугацаанд төв хогийн цэг дээр зориулалтын дагуу хаяж, хогийг ойр орчимд тархахаас сэргийлэн орон нутгийн байгууллагатай хамтран ковшоор түрэн гадаргын бохирдлоос сэргийлэн ажилласан.

2023 оны 06 сарын 08цны өдөр ОНТҮГ-тай хийсэн гэрээний дагуу хог хаягдлыг зориулалтын тээврийн хэрэгслээр төвлөрсөн хогийн цэгт хүргэн хаяж ажилласан.

Төслийн ажлын явцад ахуйн шингэн, хатуу хог хаягдал болон техникийн ШТМ газрын гадаргаас хур тунадасны усаар зөөгдөн гадаргын усыг бохирдуулах сөрөг нөлөөтэй байсан. Тиймээс манай төслийн баг ахуйн хог хаягдлыг дээр дурьдсан шиг түр хогийн цэг байгуулан гэрээний дагуу зориулалтын хогийн цэг рүү зөөвөрлөн асгаж ажилласан. Мөн ахуйн шингэн хог хаягдал болон бохирын асуудлаа соруулдаг эко байдлаар шийдэж ажилласан.

Төслийн талбайд авто хэрэгсэлүүдийн засвар үйлчилгээг хийхийг хориглон зориулалтын засвар үйлчилгээний газарт хийлгэж газрын гадаргаар дамжин гадаргын ус ШТМ-аар бохирдхоос сэргийлж ажилласан.



Зураг.1 Түр хогийн цэг байгуулан төвлөрсөн хогийн цэгт хог хаягдлыг хаяж, орон нутгийн газартай хамтран хогийн цэгийг түрэн янзлаж байгаа нь.

Төслийн талбайд автын зогсоол байгуулж, авто хэрэгсэлүүдийг зогсоолд байршуулж ШТМ асгарахаас урьдчилсан сэргийлж ажилласан. Төслийн талбайд авто хэрэгсэлүүдийн засвар үйлчилгээг хийхийг хориглон зориулалтын засвар үйлчилгээний газарт хийлгэж газрын гадарга, болон хөрсөн бүрхэвч ШТМ-аар бохирдохоос сэргийлж ажилласан.



Зураг.2 Төсөлд ашиглагдаж буй техник хэрэгслүүдийг тусгай зогсоолд байршуулан, засвар үйлчилгээг зориулалтын газар хийлгэж байгаа зураг.

Төслийн талбай, ахуйн байрны бохир болон шингэн хог хаягдлаар газрын хэвлий бохирдохоос сэргийлэн зориулалтын 00-ыг 3-4м гүнтэй ухан бетон цутган соруулдаг эко байдлаар хийсэн. Бохир соруулах гэрээг 2023 оны 06 сарын 27-ны өдөр “Хэнтий ус” ХХК-тай хийж, гэрээний дагуу үнэ төлбөрийг өгч тогтмол бохироо соруулан байгаль орчинд ээлтэй ажилласан.



Зураг.3 Төслийн талбай, ахуйн байрны бохирын шийдэл болон ус, шугам хоолой угсарч байгаа нь.

Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр

Дулааны станцын төслийн барилгын ажлуудын явцад 4 барилгын талбайгаас нийт 0.4тн ялзмагийн нөөц бүхий 3495м³ үржил шимт хөрсийг стандартын дагуу хуулан авч тусгай овоолгын талбайд хадгалан, нөхөн сэргээлтэд ашиглахаар төлөвлөн ажиллаж байна.



Зураг.7 Шимт хөрсний хуулалт хийхийн өмнөх болон хуулалт хийн овоолго үүсгэсэн байгаа зургийг хавсаргав.

Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр

Төсөлд ашиглагдаж байгаа машин техникийн зорчих замын маршрутыг тогтоон өгч заасан маршрутын дагуу замын хөдөлгөөнд оролцуулан тоосжилт үүсж агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг хянаж ажилласан. Маршрутын дагуу замын хөдөлгөөнд оролцсон ч тоосжилт ихтэй үед агаарын чанарт сөрөг нөлөө үзүүлэх байдал ажиглагдсан тул зам дагууд усалт хийж өгч ажилласан.



Зураг.4 Машин техникийн зорчих замын маршрут болон маршрутын дагуу усалгаа хийж байгааг хавсаргав.

Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр

Төслийн талбайд дулааны станцын барилгын ажил гүйцэтгэх явцад машин техникийн нөлөөгөөр мөн барилгуудын ажил эхлэхийн өмнө хийгдсэн хөрс хуулалтын үед тодорхой хэмжээний ургамлан нөмрөг сүйдсэн. Мөн төслийн нөлөөллийн бүсэд байгаа ургамлан нөмрөгийн төлөв байдал, зүйлийн бүрдлийг судалсан бөгөөд байгаль орчны менежмент төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу төсөл дууссаны дараагаар нөхөн сэргээлт хийж, дүйцүүлэн хамгаалах зорилготойгоор шимт хөрсийг овоолго үүсгэн хадгалсан.



Зураг.8 Шимт хөрсний овоолго үүсгэж, ургамлын төлөв байдлын судалгаа хийлгэж байгааг хавсаргав.

Хог хаягдлын менежмент төлөвлөгөөний хүрээнд

Төслийн талбай болон ахуйн байрнаас гарсан хатуу хог хаягдлыг ангилан ялгаж, шаардлага хангасан түр хадгалах хогийн цэг байгуулан цааш нь нэгдсэн журмаар орон нутгийн төв хогийн цэгт зөөвөрлөн хаяж, хог хаягдлаар хүрээлэн буй орчин бохирдхоос сэргийлэн ажилласан. Хог хаягдлын түр хогийн цэгийн байршлуудыг доор хавсаргав.



Зураг.9 Ахуйн байрны хатуу хог хаягдлыг хадгалах түр хогийн цэг



Зураг.10 Төслийн талбайн хатуу хог хаягдлын түр хадгалах сав

НӨХӨН СЭРГЭЭЛТ, ТОХИЖУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХҮРЭЭНД;

Төслийн хувьд барилга угсралтын ажил нийтдээ 25,6 сарын турш үргэлжлэн, ашиглалтад хүлээлгэн өгөхөөр төлөвлөсөн тул нөхөн сэргээлт, орчны тохижилттой холбоотой ажлуудыг 2023 оны байгаль орчны менежмент төлөвлөгөөнд тусгаагүй учраас нөхөн сэргээлт, орчны тохижилтийн ажил 2023 онд хийгдээгүй.

Барилгын ажлын явцад болон дууссаны дараа нөлөөлөлд өртсөн газрыг тэгшилж, дулааны станцын барилга хоорондын талбайг тохижуулах, хөрс хуулалтаас хадгалсан өнгөн хөрсөөр ургамал ургах нөхцөлийг бүрдүүлэх, нөхөн сэргээлт, орчны тохижуулалт болон явган хүний зам, автозамыг хатуу хучилттай болгох ажил хийгдэнэ.

НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХҮРЭЭНД;

Судалгааны хүрээнд тус аймагт дулааны станцын төсөлтэй холбоотой нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох айл өрх, хувь хүн, аж ахуйн нэгж байхгүй болно.

Төслийг хэрэгжүүлэх хугацаанд аймаг, сум, аж ахуйн нэгж, иргэдийн зүгээс нүүлгэн шилжүүлэх шаардлага хүргүүлээгүй тул нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаа гараагүй.

ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХҮРЭЭНД;

Хэнтий аймгийн Чингис хотод баригдах дулааны станцын төслийн үйл ажиллагаанд хамаарах талбай болон түүний орчмын нутагт нь түүх соёлын дурсгалд тооцож болохуйц газар, археологийн болон палеонтологийн олдвор одоогоор тохиолдоогүй.

Цаашид үйл ажиллагааны явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрсэн үед “Монгол Улсын Үндсэн хууль”-ийн I бүлгийн 7-р зүйлд “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна” гэж заасны дагуу түүх, соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалж хамгаалах, сурталчлах, сэргээн засварлах, өвлүүлэн уламжлуулахтай холбоотой үүрэг хариуцлагаа мөрдөж ажиллах нь зүйтэй гэсэн үүрэг хүлээн ажиллаж байна.

ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХҮРЭЭНД

Химийн бодис хүний эрүүл мэндэд нөлөөлөх сөрөг нөлөөг чиглэлээр

Хүний биед сөргөөр нөлөөлж аюулд хүргэж болзошгүй бодис, хий зэргийг зориулалтын хадгалах саванд хийн анхааруулах тэмдэг байршуулж, шаардлагатай хувцас хамгаалах хэрэгсэлээр ажилтнуудыг бүрэн хангаж ажилласан. Мөн аюултай хортой химийн бодисийн ХАЛМ-ийг ажилтнуудад танилцуулж аюулгүй ажиллагааны талаарх зааварчилгааг өгч ажилласан.



Зураг 11 Химийн хортой бодис болон хийн баллонуудыг зориулалтын хадгалах саванд хийн анхааруулах тэмдэг байршуулсан байдал.

Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр

Төсөл эхлэхээс өмнө бүх ажилтнуудад галын аюулгүй байдлын сургалт явуулж баталгаажуулан, төслийн талбай, ахуйн байр, оффис зэрэгт стандарт журмын дагуу галын хоруудыг байршуулан ажилласан. Онцгой байдлын үед төслийн багийнхан цуглах цэгийг тодорхойлж, тэмдэг байршуулсан, төслийн талбай, ахуйн байрнаас гарах бүдүүвч зургийг ажлын талбай бүр дээр байрлуулж өгсөн.



ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД

“Хасу мегаватт” ХХК-ийн Хэнтий аймгийн Чингис хотод хэрэгжүүлж буй дулааны станц барьж ашиглах төслийн орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд 2023 оны БОМТ-ний дагуу хөрс, агаар, тоосны, шинжилгээг жилд 1 удаа авч Хэнтий аймгийн УЦУОШ газрын лабораторт, ундны уснаас хагас жил тутам дээж авч итгэмжлэгдсэн лабораторт шинжлүүлж байнгын хяналт тавин ажиллаж байна.

Хөрсөн бүрхэвч

Хөрсний агро химийн үндсэн үзүүлэлтүүдийг төслийн ажил эхлэхээс өмнө төсөл хэрэгжих талбайгаас 2 цэг сонгон дээж авч “Нарт шуун консалтинг” ХХК-ний итгэмжлэгдсэн лабораторд дээжийг шинжлүүлж дүгнэлт гаргуулж авсан. Үүнд: Хөрсний химийн үндсэн үзүүлэлтүүд, хөрсний механик бүрэлдхүүн, хөрсний эрүүл ахуйн шинжилгээний дүн, хөрсний хүнд металлын үзүүлэлтүүд тус тус багтсан.



Зураг 12 Хөрсний дээж авч байга зураг болон шинжилгээний хариуг хавсаргав.

Ургамлан нөмрөг

Ургамлын зүйлийн бүрдэл, тусгаг бүрхэц, нэн ховор, ховор, ашигт ургамал ургадаг эсэх, ургамалжилтын төлөв байдлыг тодорхойлох судалгааг Хэнтий ус цаг уур, орчны шинжилгээний газартай гэрээ хийн хийлгэсэн. Мөн давхар агаарын тоосонцор болон усны шинжилгээг хийлгэсэн.



Зураг 12 Ургамлын судалгаа, агаарын дээж авч байгаа зургийг хавсаргав.

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДЛЫН ТАЙЛАН

№	Менежментийн төлөвлөгөөний зардлын агуулга	Зарцуулсан зардлын хэмжээ, мян.төг
1	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний зардал	6.460000
2	Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний зардал	2.200.000
3	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал	749.500
Нийт		9.409.500

ДУГНЭЛТ

Хэнтий аймгийн төвийн дулаан хангамжийг сайжруулах төсөл эхэлснээс хойш манайх 192 өдөр 95486 цаг аюул осолгүй, байгаль орчинд ээлтэй ажилласан байна. Энэ хугацаанд байгаль орчны эсрэг гарсан үл тохирол, зөрчилгүй ажилласан.

БОМ-ийн төлөвлөгөө боловсруулж батлуулснаар хүн болон байгаль орчинд сөргөөр нөлөөлөх нөлөөллийг цаг алдалгүй хариу арга хэмжээ авч аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.

-Байгаль орчинд сөрөг нөлөөллийг бууруулах, эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах орчныг бүрдүүлэхээр ажиллаж байна.

-Байгалийн давагдашгүй хүчин зүйл болон үер усны аюулаас урьдчилан сэргийлэх хяналтын арга хэмжээг хэрэгжүүлэх.

-Байгаль орчны тухай хууль тогтоомжийг мөрдүүлэн ажиллаж байна

ХАВСРАЛТ

Өндөрхаан тохижилт үйлчилгээний газартай байгуулсан хог хаягдал тээвэрлэх гэрээ

БАТЛАВ.
"ӨНДӨРХААН ТОХИЖИЛТЫН ГАЗАР" ОНТҮГ-Н
ЗАХИРАЛ *О. Гомбобаатар* О. ГОМБОБААТАР

ХОГ ХАЯГДЛЫН ТУХАЙ АЖ АХУЙН ГЭРЭЭ

2023 оны...-р сарын
...-ны өдөр

№ 15

Чингис хот

НЭГ: ЗОРИЛГО

Энэхүү гэрээний зорилго нь аж ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг цуглуулах, хадгалах, тээвэрлэх талаар нэг талаас гүйцэтгэгч гэх "ӨНДӨРХААН ТОХИЖИЛТЫН ГАЗАР" ОНТҮГ /цаашид гүйцэтгэгч гэх/ нөгөө талаас захиалагч болох /ХАСУ МЕГАВАТТ ХХК/ цаашид захиалагч гэх/ -ийн хооронд үүсэх эрх зүйн болон санхүүгийн харилцааг зохицуулахад оршино.

Энэхүү гэрээ нь хоёр этгээдийн эрх бүхий албан тушаалтан баталсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж мөрдөгдөнө.

ХОЁР: ГҮЙЦЭТГЭГЧ БАЙГУУЛЛАГЫН ЭРХ, ҮҮРЭГ

1. Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалахтай холбогдсон хууль, дүрэм, стандартын шаардлагыг ханган ажиллана.
2. Хог хаягдлыг тээвэрлэх аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан битүүмжилсэн тээврийн хэрэгслээр тогтоосон чиглэлийн дагуу тээвэрлэх.
3. Хог хаягдлыг дарж булшлахтай холбогдсон хууль, дүрэм журам, стандартын шаардлагыг ханган ажиллана.
4. Шаардлагатай тохиолдолд захиалагчийн дуудлагаар нэмэлт үйлчилгээ хийж хог хаягдлыг булшлах.
5. Хэнтий аймаг иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 04 дугаар "хог хаягдал тээвэрлэх зардал, үйлчилгээний хэмжээг тогтоох тухай" тогтоолын дагуу хураамж төлөх.
6. Гэрээний хугацаа 2023 оны 06 сарын 08-с 2023 оны 12 сарын 31.

ГУРАВ: ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

1. Эрхлэн байгаа үйлдвэрлэл үйлчилгээний улмаар үүсэж байгаа хог хаягдлыг хог хаягдал хадгалах түр цэгт хаях.
2. Хог хаягдлыг тээвэрлэх аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан битүүмжилсэн тээврийн хэрэгслээр тогтоосон чиглэлийн дагуу тээвэрлэх.

3. Хог хаягдлын талаарх хууль, дүрэм журмыг мөрдөн тэдгээрийн шаардлагыг ханган ажиллах.
4. Гүйцэтгэгч байгууллагатай гэрээ байгуулан гэрээгээр авсан үүрэг шаардлагыг биелүүлэх.
5. Хог хаягдлын талаарх мэдлэгийг ажилтнууддаа эзэмшүүлэн аюулгүй ажиллагааны шаардлагыг ханган ажиллах ба хог хаягдлыг цэгт шатаахгүй хаях.
6. Захиалагч нь орчин тойрныхоо хог хаягдлыг цэвэрлэх олон нийтийг хамарсан ажилд идэвхтэй оролцох.
7. Аюултай хог хаягдлын талаарх мэдээллийг захиалагч нь гэрээ хийх үед урьдчилан танилцуулах.
8. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг бүрийн 25-ны дотор Хэнтий аймгийн татварын хэлтэст төлөх.

Үйлчилгээний хураамж 45000 төгрөг.

ДӨРӨВ: ХАМТРАН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

1. Хоёр тал гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд Монгол улсын үндсэн хууль, байгаль орчныг хамгаалах тухай хууль, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хууль, ариун цэврийн тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.
2. Захиалагч нь гэрээний 3 дугаар зүйлийн 6 дахь заалтыг биелүүлээгүй тохиолдолд гарсан төлбөрийг барагдуулж, цаашид гэрээг цуцална.
3. Захиалагч этгээд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд үүссэн асуудал, гарсан хохирлыг маргаангүйгээр шийдвэрлэнэ.

Гэрээ байгуулсан:

Гүйцэтгэгч байгууллагыг төлөөлж:

“ӨНДӨРХААН ТОХИЖИЛТЫН ГАЗАР”
Мэргэжилтэн /МОНС/ Ц. Хатанболд/

Утас: 70562137, 98562137

Байршил: III баг

150 18 17 00 947

Захиалагчийг төлөөлж:

А. Яунбаатар
Захирал..... /

Нягтлан бодогч..... /

Утас: 99034612

Байршил:..... баг

Өндөрхаан тохижилт үйлчилгээний газартай байгуулсан хог хаягдал тээвэрлэх гэрээ

Сумын иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2023 оны
02 дугаар сарын 13-ны өдрийн Хурал тавдугаар
хуралдааны 1 дүгээр дугаар 02- хавсралт



ХЭРЛЭН СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ МӨРДӨХ ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САРЫН ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ

№	Айл өрх, ААН, Байгууллага	Хоногт гарах хогны хэмжээ /тонн/	Хураамж /сард,төг/	
1. Энгийн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, булшлах үйлчилгээний хураамж				
1	Төвлөрсөн халаалттай болон галлагаатай орон сууц, гэр хорооллын айл өрх	0,003	8000	
2	Нийтийн болон дотуур байр	0,033	39000	
3	Зочид буудал, амралтын газар	15 хүртэлх ортой	0,026	40000
		15-30 ортой	0,040	70000
		30-аас дээш ортой	0,050	88000
4	Хүүхдийн цэцэрлэг, ясли	0,033	39000	
5	Ерөнхий боловсролын сургууль	0,050	88000	
6	Номын сан, музей	0,013	17000	
7	Кинотеатр, соёлын төв	50-150 хүний суудалтай	0,045	57000
		50 хүртэлх хүний суудалтай	0,031	40000
		150-350 хүний суудалтай	0,050	88000
		350-аас дээш хүний суудалтай	0,081	100000
8	Цэнгэлдэх хүрээлэн, спортын ордон	0,045	57000	
9	Сүм, хийд болон олон нийтийн амралт зугаалгын бүсийн цэвэрлэгээ	0,016	28000	
10	Худалдааны төв, зах, төрөлжсөн дэлгүүр, бөөний төв	40м ² -аас бага талбайтай	0,013	17000
		40м ² -100м ² талбайтай	0,021	36400
		100м ² -200м ² талбайтай	0,040	70000
		200м ² -400м ² талбайтай	0,115	175000
		400м ² -600м ² талбайтай	0,230	350000
		600м ² -800м ² талбайтай	0,423	650000
		800м ² -аас дээш талбайтай	0,692	1059000
11	Ресторан, гуанз бар, кафе	20 хүний суудалтай	0,026	45000
		20-50 хүний суудалтай	0,045	57000
		50-аас дээш хүний суудалтай	0,050	88000
12	Талх, нарийн боов, хэрчсэн гурил, хиам, зайрмаг, цэвэр усны цех болон бусад жижиг үйлдвэр	0,013	17000	
13	Үсчин, ахуйн үйлчилгээ, гутал засвар, оёдлын цех, гар утас засвар, тоглоомын газар, зурагчин, компьютер үйлчилгээ	0,013	17000	
14	Албан байгууллага, ажлын өрөө	10 хүртэлх ажиллагсадтай	0,013	17000
		10-20 ажиллагсадтай	0,016	28000
		20 ба түүнээс дээш ажиллагсадтай	0,036	45000
15	Авто тээврийн товчоо, нисэх онгоцны буудал	0,050	88000	

Хэнтий аймгийн УЦУОШГ-тай байгуулсан хөрс, агаар, усны шинжилгээний гэрээ

БАТЛАВ.
УЦУОШТ-ИЙН ДАРГА

Б.ХЭРГИЭНЧИМЭГ

БАТЛАВ.
ХАСУ
ГҮЙ
МЕГАВАТТ ХХК
ЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Т.ОРГИЛ

Чингис хот

2023 он 09 сар 05 өдөр

Монгол Улсын Иргэний хуулийн 343-358 дугаар зүйлийг удирдлага болгон энэхүү гэрээг нэг талаас захиалагч "ХАСУМЕГАВАТТ" ХХК -г төлөөлж Тэргүүн дэд захирал бөгөөд ерөнхий инженер Ю.Энх-Амгалан /цаашид захиалагч гэнэ/, нөгөө талаас Хэнтий аймгийн УЦУОШТ-ийн БОШЛ-ын эрхлэгч, инженер Б.Ганганбайгал /цаашид гүйцэтгэгч гэнэ/ нар харилцан тохиролцож байгуулав.

1. Нийтлэг үндэслэл

- 1.1 Гүйцэтгэгч байгууллага нь захиалагч байгууллагын хүсэлтээр 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заасан орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу орчны шинжилгээний дээжийг авна.
- 1.2 Гүйцэтгэгч байгууллага нь дараахи үзүүлэлтээр шинжилгээг хийж дурьдсан хугацаанд үр дүнг хүргүүлнэ.

Дээжийн нэр	Үзүүлэлтүүд	Тодорхойлох арга	Хяналтын цэгийн тоо
Агаарын чанар	Хүхэрлэг хий (SO ₂)	20 минут автомат анализатор	1
	Азотын давхар исэл (NO ₂)	20 минут автомат анализатор	
	Тоосонцор PM _{2.5}	Шууд	1
Усны чанар	Тоосонцор PM ₁₀	Шууд	1
		Тооцооны болон бусад аргууд	

- 1.3 Байгаль орчны хяналт шинжилгээний ажлын үнэ, төлбөрийг БОАЖЯ-ны сайдын 2019 оны 05.06 өдрийн А/164 тоот тушаалаар батлагдсан журмыг баримтлан тогтооно.

Хэнтий аймгийн УЦУОШГ-тай байгуулсан хөрс, агаар, усны шинжилгээний гэрээ

А. Агаарын чанар

№	Тодорхойлох үзүүлэлт	Үнэ /төгрөг/
1	Хүхэрлэг хий (SO ₂)	12500
2	Азотын давхар исэл (NO ₂)	12500
Нийт		25000

Б. Усны чанар

№	Тодорхойлох үзүүлэлт	Үнэ /төгрөг/
1	Усан орчин /рН/	1500
2	Цахилгаан дамжуулах чанар /Ес/	1500
3	Булингаршил	1000
4	Жинлэгдсэн бодис	5000
5	Ууссан хүчилтөрөгч /Шууд/	1500
6	Ууссан хүчилтөрөгч	3500
7	Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч	17000
8	Переманганатын исэлдэх чанар	5500
9	Хатуулаг	1500
10	Кальцийн ион	1500
	Магнийн ион	1000
12	Натри+Калийн ион	1000
13	Гидрокарбонатын ион	2500
14	Хлорын ион	2500
15	Сульфатын ион	3500
16	Эрдэсжилт	1500
17	Аммонийн азот	3500
18	Нитритийн азот	3000
19	Нитратын азот	4000
20	Эрдэс фосфор	2500
21	Төмөр	2500
22	Фтор	2500
Нийт		69500

1.4. Гэрээний хугацаа

- Ажил гүйцэтгэх ерөнхий хугацаа- 2023 оны 08 дугаар сар
- Ажил эхлэх хугацаа - 2023 оны 08дугаар сарын 31
- Ажил дуусах хугацаа- 2023 оны 09 дүгээр сарын 15

2. Захиалагчийн эрх үүрэг

2.1. Захиалагч нь ажил гүйцэтгэхэд шаардагдах нөхцөлийг бүрдүүлж өгнө. Үүнд:

- Шинжилгээний сорьц авах объект нь УЦУОШТ-ны БОШЛ-аас 5 км-с хол зайд байрладаг бол унаагаар хангах.
- Сорьц авах шаардлагатай бүс газарт саадгүй нэвтрүүлэх

Хэнтий аймгийн УЦУОШГ-тай байгуулсан хөрс, агаар, усны шинжилгээний гэрээ

- Сорьц авах багаж, төхөөрөмжийг ажиллуулахад шаардлагатай цахилгааны эх үүсвэрээр хангах

- 2.2. Хөдөө орон нутагт ажиллах бол ажиллах хугацааны унаа, хоол, байрны зардлыг бүрэн хариуцна.
- 2.3. Дээж авах үед ажилтны хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн дэглэмийг баримталж аюулгүй ажиллагааны зөвлөгөө, хамгаалах хувцас, хэрэглэлээр хангах.
- 2.4. Гүйцэтгэгч хүссэн тохиолдолд шинжилгээ хийлгэх объектийн талаархи мэдээлэл өгөх.
- 2.5. Гүйцэтгэгчийн ажил үйлчилгээний явцад хяналт тавих
- 2.6. Захиалагч байгууллага гэрээ байгуулсаны дараа ажил эхлэхийн өмнө шинжилгээний үнэ, ажиллах ажилтны унаа, томилолтын зардлыг бүрэн шилжүүлсэн байна.

3. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

- 3.1. Тухайн байгууллагын 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу сорьц авч шинжилгээ хийнэ.
- 3.2. Сорьц авч, шинжилгээ хийх ажлыг мэргэжлийн ажилтнаар биечлэн гүйцэтгүүлнэ.
- 3.3. Сорилын дүнг гэрээнд заасан хугацаанд захиалагчид гаргаж өгөх
- 3.4. Сорьц авах объектэд ажиллах нөхцөл, хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн шаардлага хангахыг шаардах
- 3.5. Захиалагч ажлын үр дүнг хугацаанд нь авах үүргээ биелүүлээгүй бол ажлын үр дүнг хүлээн авсанд тооцож хөлс төлөхийг захиалагчаас шаардах эрхтэй.
- 3.6. Захиалагч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс шалтгаалж захиалагчид учирсан хохирлыг гүйцэтгэгч хариуцахгүй.

4. Ажлын хөлс, төлбөр тооцоо

- 4.1. Гэрээгээр гүйцэтгэх ажлын нэгж объектоос дээж авч шинжилгээ хийсний нийт төлбөр болох **234.500** төгрөг /үсгээр/ (*Хоёр зуун гучин дөрвөн мянга таван зуун төгрөг* / байна.

Шинжилгээний дээж авах байршлын тоо, үнэлгээ / Урьдчилсан байдлаар/

№	Шинжилгээний сорьц авах байршил /Хаяг/	Шинжилгээний сорьцийн тоо					
		Ус	Ургамал	Агаар	Тоосонцор	Цацраг	
						Хөрс	Агаар
1	Хасу мегаватт ХХК	1	1	1	1		
Нийт тоо							
Үнэ /төгрөг/	Нэгж	69.500	90.000	25.000	50.000	5000	5000
	Бүгд	69500	90.000	25.000	0	0	0

Дүн- **234.500** төгрөг



Хэнтий аймгийн УЦУОШГ-тай байгуулсан хөрс, агаар, усны шинжилгээний гэрээ

- 4.2 Ажил гүйцэтгэсний төлбөр **234.500** төгрөг /үсгээр/ (Хоёр зуун гучин дөрвөн мянга таван зуун төгрөг /төгрөг 2023 оны 05 дугаар сарын 10 -ны дотор манай байгууллагын Төрийн сан банк **100180013402** тоот дансанд " Шинжилгээний үнэ" утгаар шилжүүлсэн байна.

5. Талуудын хүлээх хариуцлага

- 5.1 Гүйцэтгэгч ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй бол хугацааг хэтрүүлсэн хоног тутамд 0.05 хувийн алданги төлнө.
- 5.2 Захиалагч төлбөрөө гэрээнд заасан хугацаанаас хэтрүүлсэн хоног тутамд 0.05 хувийн алданги төлнө.
- 5.3. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс учруулсан хохирлыг гэм буруутай тал нь хохирогч талдаа нөхөн төлөх үүрэгтэй.
- 5.4. Гэрээг 2 хувь үйлдэх ба талууд 1 хувийг хадгална.

6. Бусад заалт

- 6.1 Гэрээ байгуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
- 6.2 Гэрээний хугацаа, нөхцөл байдлын талаар өөрчлөлт оруулахаар бол хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэнэ.
- 6.3 Талуудын хооронд маргаан гарвал талууд үл маргах журмаар шийдвэрлэх ба маргаанаа шийдвэрлэж чадахгүйд хүрвэл харьяалах шүүхээр шийдвэрлүүлнэ.

7. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах журам

Ажил гүйцэтгэх явцад гэрээнд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж талуудын гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

Учруулсан хохирлыг арилгахтай холбогдсон хууль тогтоомжид заасан үндэслэлээр 2 тал харилцан тохиролцож гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж болно.

Гэрээ байгуулсан:

Захиалагч : "ХАСУ МЕГАВАТТ" ХХК-ийг төлөөлж

"ХАСУ МЕГАВАТТ" ХХК-ийн Тэргүүн дэд захирал бөгөөд ерөнхий инженер: Ю.Энх-Амгалан




Хаяг: Баянгол дүүрэг, Эрчим хүчний гудам
20-р хороо, "Хасу мегаватт" ХХК-ийн байр

Утас:75009999

Гүйцэтгэгч: УЦУОШТ-ийг
БОШЛ-ын эрхлэгч, инженер

Б.Ганганбайгаль



Хаяг: Тэмүүжин гудамж Н-13

Утас: 98092200



Хэнтий УС компанитай байгуулсан цэвэр усаар хангах, бохир ус татан зайлуулах гэрээ

БАТЛАВ:
БАЙГУУЛЛАГЫН НЭР: "ХЭНТИЙ-УС ХХК"
АЛБАН ТУШААЛ: ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ


ХЭНТИЙ УС
ХХК
Г.БАТГЭРЭЛ

БАТЛАВ:
БАЙГУУЛЛАГЫН НЭР: ХАСУ МЕГАВАТТ
АЛБАН ТУШААЛ: ТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАЛ
БӨГӨӨД ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР


Н.ЖАМБАЛОВ
Ю.ЭНХ-АМГАЛАН

УС АШИГЛАЛТЫН ГЭРЭЭ

20. 03 оны 03 сарын
07 -ны өдөр

№

Чингис хот

Бохир усанг

Нэг : Ерөнхий зүйл

Энэхүү гэрээ нь хэрэглэгч хангагч байгууллагын хоорондын харилцааг шийдвэрлэх, санхүү төлбөрийн болон ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилготой.

Гэрээг нэг талаас "ХЭНТИЙ-УС" ХХК "–ийг төлөөлж Хэрэглэгчийн албаны дарга .ажилтай Алтанхуяг овогтой Балжинням./цаашид/" Хангагч байгууллага " гэх / нөгөө талаас Хэрэглэгчийг төлөөлж Кемп менежер ажилтай Лхагва овогтой Гэцэнбалбар /цаашид хэрэглэгч байгууллага гэх / нар харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Хоёр: Хангагч байгууллагын эрх, үүрэг

- 2.1. Хангагч байгууллага нь хэрэглэгчийг стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах,
- 2.2. Хэрэглэгчдээс гарсан санал хүсэлтийг хүлээн авч шуурхай барагдуулах,
- 2.3. Ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын талаарх хууль тогтоомж, дүрэм, заавар, норм, стандартыг үйл ажиллагаандаа мөрдөх,
- 2.4. Гэнэтийн осол, аваар гарсан болон зайлшгүй урьдчилан сэргийлэх, засвар, үйлчилгээ хийх үед энэ тухай хэрэглэгчдэд урьдчилан мэдэгдэх,
- 2.5. Хэрэглэгчийн усны тоолуурын найдвартай ажиллагааг хангах үүднээс худалдах, суурилуулах ажлыг цагт тухайд нь хийх,
- 2.6. Хангагч байгууллага нь төлбөрийн нэхэмжлэлийг хэрэглэгчид сар бүрийн 15-25-нд байгууллагын ажлын байранд байгаа дарга, ня-бо, нярав, хариуцсан мэргэжилтэнд бичилтийн баримтыг хүргэж өгнө.
- 2.7. Тооцооны хэмжих хэрэгсэл болон тооцоо хийсэн ажилтны буруугаас гарсан төлбөр тооцооны зөрүүг талууд харилцан тохиролцож дараа сарын тооцоонд оруулан нөхөн бичиж тооцно.
- 2.8. Хангагч ба хэрэглэгчид өөрийн байршил, харилцагч банкны дансны дугаар, хаягийн бүртгэл солигдох, өөрчлөгдөх бүр гэрээнд тодотгол хийнэ.
- 2.9. Хэрэглэгч нь энэхүү гэрээний 4 дугаар зүйлийн 4, 6-д заасан үүргээ биег үүлээгүй тохиолдолд хангагч талаас урьдчилан мэдэгдэж цэвэр, бохир усанд хязгаарлалт хийж эрхтэй.
- 2.10. Цэвэр бохир усны үнэ тарифын өөрчлөлтийн талаар түүнийг мөрдөж эхлэхээс 30 хоногийн өмнө, төлөвлөгөөт засвар хийх үед цэвэр усаар хангах үйл ажиллагааг түр зогсоох тухай хэрэгдэгчид урьчилан мэдэгдэх буюу хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлана.
- 2.11. Талууд бичгээр харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээний үндэс өөрчлөлт оруулна.

Хэнтий УС компанитай байгуулсан цэвэр усаар хангах, бохир ус татан зайлуулах гэрээ

Гурав: Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

- 3.1 Хэрэглэгч нь ус хангамжийн байгууламж, ариутгах татуургын шугам сүлжээнд зөвшөөрөлгүй холболт хийсэн, хангагч байгууллагын лац хөдөлгөсөн, усны тоолуурын битүүмжлэл, байрлал, холболтыг дур мэдэн өөрчилсөн тохиолдолд:
- 3.2 Цэвэр усыг хязгаарлаж Монгол улсын хот суурины усан хангамж ариутгах татуургын, ашиглалтын тухай хуулийн дагуу:
- 3.2.1. А) Иргэнийг 1 сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 3-4 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр,
Б) албан тушаалтныг 1 сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 4-5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох,
- 3.2.2. ААН, байгууллагыг 1 сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5-10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох
- 3.2.3. Хангагч, хэрэглэгчийн хооронд үүссэн маргааныг шүүх болон мэргэжлийн хяналтын газарт хандаж асуудлыг тавьж шийдвэрлүүлнэ.
Хэрэглэгч нь гэрээнд заасан хугацаанд төлбөрөө төлөөгүй тохиолдолд хэрэглээг хязгаарлаж салгалт болон залгалтын хөлсийг нэхэмжилж авна.
- 3.2.4. Хугацаа хэтэрсэн хоногт тутамд төлбөл зохих үнийн дүнгийн 0.5% -тай тэнцэх хэмжээний алданги тооцож төлүүлэх. Алдангийн нийт хэмжээ гэрээний үнийн дүнгийн 10 хувиас хэтрэхгүй байна.
- 3.2.5. Төлбөрөө төлөөгүй тохиолдолд алдангитай дүнгээр шүүхийн байгууллагад нэхэмжлэл гаргах арга хэмжээ авч хэрэглэгчийг төлбөрөө бүрэн барагдуулж дуустал цэвэр усаар хангахгүй байх.
- 3.2.6. Ажил үүргээ гүйцэтгэж байгаа ажилтанг хэл амаар доромжлох, нэр төрд нь халдах, айлган сүрдүүлсэн бол зохих хууль дүрмийн дагуу хариуцлага хүлээлгэх, хууль хяналтын байгууллагад өгч шийдвэрлүүлнэ.
- 3.2.7. Хэрэглэгч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд цэвэр усаар хангахгүй болно.

Дөрөв: Хэрэглэгчийн эрх, үүрэг

- 4.1. Хэрэглэгч нь стандартад нийцсэн цэвэр усаар хангуулах, хэрэглээнээс гарсан бохир усаа хангагчийн шугам сүлжээнд нийлүүлэх,
- 4.2.
- 4.3. Хэрэглэгч өөрийн эзэмшилд байгаа шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хангах, засвар, үйлчилгээ хийх ажлыг өөрийн хөрөнгөөр гүйцэтгэнэ.
- 4.4. Хэрэглэгч өөрийн эзэмшилд байгаа тоног төхөөрөмж, шугам сүлжээнд гэмтэл учруулсан бол шаардагдах засварыг өөрөө, бололцоогүй бол хангагчаар хийлгэж, гарсан зардлыг төлөх,
- 4.5. Хэрэглэгч нь хангагчийг тоолуурын заалт, лац, шугам сүлжээ, тоног төхөөрөмжид үзлэг, шалгалт хийх зэрэг үйл ажиллагаагаа явуулах нөхцөл бололцоогоор хангах үүрэгтэй,
- 4.6. Хэрэглэгч нь цэвэр ус түгээх, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах үйлчилгээний төлбөрийг ирүүлсэн нэхэмжлэлд үндэслэн дараа сарын 05-ний дотор төлөх үүрэгтэй
- 4.7. Тооцооны хэмжих хэрэгслийн гэмтэл, эвдрэл нь хэрэглэгчээс шалтгаалаагүй, эсвэл тооцооны хэмжих хэрэгслийг шалгаж засварлах, баталгаажуулах зорилгоор шугамаас салгасан бол өмнөх 3 сард хэрэглэсэн цэвэр ус, татан зайлуулсан бохир усны хэмжээний дунджаар тооцно.
- 4.8. Хэрэглэгч нь гэрээгээ цуцлах шаардлага гарсан тохиолдолд хангагч байгууллагад бичгээр ажлын 5 хоногийн өмнө урьдчилан мэдэгдэнэ.

Хэнтий УС компанитай байгуулсан цэвэр усаар хангах, бохир ус татан зайлуулах гэрээ

- 4.9. Хэрэглэгч нь цэвэр усаар хангуулах, бохир усыг татан зайлуулах үйлчилгээг авах бол хангагч байгууллагад хандаж зөвшөөрөл авч ус ашиглалтын гэрээг хариуцсан ажилтантай байгуулна.
- 4.10. Хэрэглэгч өөрсдийн хэрэглээний бохирыг зайлуулахдаа Эрчимийн зүүн талд байрлах насос станцын анхны худагт хийх
- 4.11. Бохиороо зайлуулахдаа насос станцын ээлжинд гарч буй машинистад тэмдэглүүлэх
- 4.12. Ийм тохиолдолд бохир усны бичилтийг цэвэр усны заалтаар тооцно.
- 4.13. Хэрэглэгч нь жилд 2 удаа / **хагас жилээр, жилийн эцэст** / -хангагч байгууллагад ирж нягтлан бодогчтой тооцоо нийлж, тооцоо нийлсэн актад гарын үсэг зурж баталгаажуулах

Тав: Хэрэглээг тодорхойлох

- 5.1. Хэрэглэгчдийн усны хэрэглээг тодорхойлохдоо баталгаажуулсан усны тоолуураар, хэрэв тоолуургүй тохиолдолд Байгаль Орчны Сайдын 1995 оны 153-р тушаалын хавсралт-2 /ахуй үйлчилгээний газруудад мөрдөх ус хэрэглээний түр нормоор тооцно.
- 5.2. Талууд дараах байдлаар хэрэглээний төрөл болон үнэ, төлбөрийн мэдээллийг харилцан тохиролцож шийдвэрлэнэ.
- 5.3. Хэрэглээ, хангамжийн төрөл, үнийн мэдээлэлд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай тохиолдолд талуудын бичгэн хэлбэрээр харилцан тохиролцож гэрээнд хавсаргана.
- 5.4. Гэрээнд заах үйлчилгээний төрөл, гэрээний зүйлийн үнийн мэдээлэл зэрэг гол нөхцлүүдийг бичгээр тохиролцоогүй тохиолдолд гэрээг хүчинтэй гэж үзэхгүй.
- 5.5. **Нэг удаагийн бохирын соролтын үнэ 165,000 .төгрөг / татуулна.**
- 5.6. 1 КМ Т ногдох үнэлгээ ..төгрөг . ирж буцах нийт км-.....

Гэрээ байгуулсан:

Хангагч байгууллагыг төлөөлж:

Хэрэглэгчийн алба: А.Балжинням
Гарын үсэг:
Албан утас: 70562366
Гар утас: 96060709

Гэрээ байгуулсан:

Хэрэглэгч байгууллагыг төлөөлж:

Комп менежер: Л.Гэцэнбалбар
Гарын үсэг:
Албан утас: 75009999
Гар утас: 99034612

Гар утас: 96060709

Регистрийн дугаар: 2643987

Банкны харилцах данс:

Хаан банк -5935003366

банк:.....

Хас банк- 5000031687

Төрийн банк- 250000425

банк:.....

Регистрийн дугаар: 2656124


Банкны харилцах данс:

Хаан

Хасбанк:.....

Төрийн

Усны шинжилгээний хариу



УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ


Хэнтий аймаг Хэрлэн сум 2-р баг
Тэмүүжингийн гудамж Н-13
Утас/Факс: 93028611, 98092200
E-mail хаяг: mnhe_oper@yahoo.com



Сорьцын дугаар: 48
Сорьц авсан газрын нэр, хаяг, утас: "ХАСУ МЕГАВАТТ ХХК" ЦЭВЭРЛЭХ
БАЙГУУЛАМЖ
Сорьц авсан хүний нэр, албан тушаал: Агаарын техникч Б.Эрдэнэцэцэг
Сорьцын тоо, хэмжээ: 2,5 литр
Сорьцын төрөл: Ус
Сорьц авсан огноо: 2023-09-01
Лабораторид хүлээж авсан : 2023-09-01
Шинжилгээ эхэлсэн огноо: 2023-09-03
Хэвлэсэн огноо: 2023-10-10
Хуудасны тоо: 1/1

ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

Тодорхойлсон үзүүлэлт Шинжилгээний арга стандарт	Сорьц авсан цэг	MNS 900:2018	
		Ундны ус	Хүлцэх агууламж мг/л
Жинлэгдэх бодис /MNS 6836:2020/	Ж/Б мг/л	6.6	
Перманганатын исэлдэх чанар /MNS 6833:2020/	Пич мг/л	0.64	
Кальцийн ион /MNS ISO 1097:1970/	Ca ²⁺ мг/л	63.2	100.0
Магний ион /MNS ISO 1097:1970/	Mg ²⁺ мг/л	5.08	30.0
Аммоний ион /CA3 1:2020/	NH ₄ ⁺ мг/л	илр	1.5
Нийт төмөр /MNS 4430:2005/	Fe мг/л	0.03	0.3
Хлорийн ион /MNS 4424:2005/	Cl ⁻ мг/л	8.3	350
Сульфатын ион /MNS 6271:2011/	SO ₄ ²⁻ мг/л	14.0	500.0
Нитритийн ион /MNS 6779:2019/	NO ₂ мг/л	0.001	1.0
Нитратын ион /MNS 6834:2020/	NO ₃ мг/л	2.45	50.0
Фосфатын ион /MNS ISO 6878:2001/	PO ₄ ³⁻ мг/л	0.002	3.5
Фтор /MNS 6272:2011/	F ⁻ мг/л	2.02	0.7-1.5
Хатуулаг /MNS ISO 1097:1970/	Хатуулаг мг-экв/л	3.57	7.0
Натри Кали	Na+K мг/л	16.3	-
Цахилгаан дамжуулах чанар /MNS ISO 7888:1999/	EC μS/cm ³	464.0	1000
Гидрокарбонат MNS 6832:2020	HCO ₃ ⁻ мг/л	225.7	-
Эрдэсжилт MNS ISO 1097:1970	мг/л	332.7	-
Орчин MNS ISO 10523:2001	pH	7.60	6.5-8.5


 ХЯНАЖ БАТААГААХУЙГДСАН:
 УЦУОШТӨВИЙН ДАРГА /Б.ХЭРЛЭНЧИМЭГ /
 ШИНЖИЛГЭЭНИЙ ЦЭТГЭСЭН:
 БОШ ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧИЙН /Б.ГАНГАНБАЙГАЛ /

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нэвчхөн шинжилсэн сорьцонд хамаарна.

Агаарын шинжилгээний хариу



УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

Хэнтий аймаг Хэрлэн сум 2-р баг тэмүүжингийн
гудамж Н-13
Утас/Факс: 93028611, 98092200
E-mail хаяг: mnhe_oper@yahoo.com



Сорьцын дугаар: 38
Сорьц авсан газрын нэр, хаяг, утас: "ХАСУ МЕГАВАТТ ХХК" ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖ
Сорьц авсан хүний нэр, албан тушаал: Агаарын техникч Б.Эрдэнэцэцэг
Сорьцын тоо, хэмжээ:
Сорьцын төрөл: Агаар
Сорьц авсан огноо: 2023-09-01
Лабораторид хүлээж авсан : 2023-09-01
Шинжилгээ эхэлсэн огноо: 2023-09-02
Хэвлэсэн огноо: 2023-09-30
Хуудасны тоо: 1/1

ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

Шинжилсэн үзүүлэлтийн нэр, хэмжих нэгж	Хүлцэх агууламж	Үр дүн
MNS 17.2.5. 12:88	Хүхэрлэгхий – SO ₂ , мг/м ³	0.450 0.002
MNS 17.2.5. 12:88	Азотын давхар исэл – NO ₂ , мг/м ³	0.200 0.022

ХЯНАЖ БАТГААГАДСАН:
УЦУОШТӨВИЙН ДАРГА: /Б.ХЭРЛЭНЧИМЭГ /-Г
ШИНЖИЛГЭЭНИЙН ЭГСЭН:
БОШ ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ: /Б.ГАНГАНБАЙГАЛ /

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хамаарна.

Агаарын шинжилгээний хариу



УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

Хэнтий аймаг Хэрлэн сум 2-р баг тэмүүжингийн
гудамж Н-13

Утас/Факс: 93028611, 98092200
E-mail хаяг: mnhe_oper@yahoo.com



Сорьцын дугаар: 38
Сорьц авсан газрын нэр, хаяг, утас: "ХАСУ МЕГАВАТТ ХХК" ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖ
Сорьц авсан хүний нэр, албан тушаал: Агаарын техникч Б.Эрдэнэцэцэг
Сорьцын тоо, хэмжээ:
Сорьцын төрөл: Тоос
Сорьц авсан огноо: 2023-09-01
Лабораторид хүлээж авсан : 2023-09-01
Шинжилгээ эхэлсэн огноо: 2023-09-02
Хэвлэсэн огноо: 2023-09-30
Хуудасны тоо: 1/1

ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

Шинжилсэн үзүүлэлтийн нэр, хэмжих нэгж	Хүлцэх агууламж	Үр дүн
САЗ А03	Тоос – нийт, мг-м3	0.150 0.048

ХЯНАЖ БАТАЛГААЖУУЛСАН:
УЦУОШТӨВИЙН ДАРГА:  /Б.ХЭРЛЭНЧИМЭГ /-г
ШИНЖИЛГЭЭ ГҮЙЦЭТГЭСЭН:
БОШ ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ:  /Б.ГАНГАНБАЙГАЛ /

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хамаарна.

Ургамлын төлөв байдлын шинжилгээ

Бэлчээрийн төлөв байдлын ажиглалт-2023

Бэлчээрийн төлөв байдлын ажиглалт хийсэн тухай тэмдэглэл

Хэнтий аймгийн Хэрлэн сумын нутаг дэвсгэрт Дулааны станцын орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдөр бэлчээрийн мониторингийн 1 цэгт бэлчээрийн төлөв байдал тодорхойлох ажиглалтыг БОАЖЯ-ны сайдын батласан аргазүйн дагуу хийж гүйцэтгэлээ.

Судалгааны цэгийн байршил



Ургамлын төлөв байдлын шинжилгээ

Бэлчээрийн төлөв байдлын ажиглалт-2023

Энэхүү судалгааны ажиглалтаар дараахи үзүүлэлтүүдийг тодорхойллоо. Үүнд:

1. Бэлчээрийн ургамлын зүйлийн бүрдэл
2. Бэлчээрийн зонхилох ургамлын өндөр(см)
3. Бэлчээрийн ургамлын ургац (ц/га, кг/га)
4. Бэлчээрийн ургамлан нөмрөгийн бүрхэц
5. Бэлчээрийн талхагдал
6. Хөрсний элэгдэл эвдрэл

Судалгааны арга зүй

Бэлчээрийн ургамлын голлох зүйлийн бүрэлдэхүүн, ургац, бүрхэц, голлох ургамлын дундаж өндөр тодорхойлох ажиглалтуудыг БОАЖЯ-ны сайдын 2011 оны А/114 тоот тушаалаар батлагдсан Шугам цэгийн арга зүйгээр хийлээ.

Ургамлын зүйлийн бүрэлдэхүүн тодорхойлохдоо 50м шугаман дээр 25 см тутам нийт 200 цэг дээр ургамлын оройн бүрхэц, дэд бүрхэц, суурийн бүрхэцийг тодорхойлсон.

Дээрхи үзүүлэлтүүдийг тодорхойлохын зэрэгцээ тухайн мониторингийн цэг орчмын бэлчээрийн төлөв байдлыг фото зургаар баримтжуулсан. Судалгаа ажиглалтын үр дүнд тулгуурлан *Бэлчээрийн төлөв байдал, сэргэх чадварын ангилал*-ыг тооцож гаргалаа.

Ургамлын төлөв байдлын шинжилгээ

Бэлчээрийн төлөв байдлын ажиглалт-2023

Судалгааны үр дүн

Дулааны станц / Нөлөөллийн бүсийн доод талд/

N 47. 19. 47.2 E 110. 41. 06.6



Бэлчээрийн төрөл: Чулуурхаг хөрстэй уулын орой, энгэр хажуугийн чулуусаг алаг өвс – жижиг дэгнүүлт үетэнт бэлчээр

Бэлчээрийн төлөв байдал – Доройтсон төлөв байдал

Сэргэх чадварын ангилал – IV

Бэлчээрийн ургац (ц/га) – 3.9 ц/га

Ургамлын төлөв байдлын шинжилгээ

Бэлчээрийн төлөв байдлын ажиглалт-2023

Бэлчээрийн ургамлын зүйлийн бүрэлдэхүүн

Зонхилогч	Зүйлийн нэр		Эзлэх хувь	Өндөр /см/
	Латин нэр	Монгол нэр		
Дэд зонхилогч	<i>Chenopodium acuminatum</i> Willd.	Шоргор лууль	35	23
	<i>Carex duriuscula</i> C.A.Mey.	Ширэг улалж	32	9
	<i>Artemisia Adamsii</i> Bess.	Адамсын шарилж	10	17
	<i>Corispermum mongolicum</i> Iljin	Монгол хамхуул	7	15
	<i>Chloris virgata</i> Sw.	Саваан булган сүүл	4	14
	<i>Eragrostis minor</i> Host	Бага хургалж	2	11
	<i>Heteropappus hispidus</i> (Thunbg.) Less.	Арзгар согсоолж	2	17
	<i>Potentilla bifurca</i> L.	Имт гичгэнэ	2	6
	<i>Artemisia frigida</i> Willd.	Агь	2	7
	<i>Cleistogenes squarrosa</i> (Trin.) Keng.	Дэрвээн хазаар өвс	1	11
	<i>Bupleurum bicaule</i> Helm.	Хоёр ишт бириш	1	28
	<i>Achnatherum splendens</i> (Trin.)Nevski	Гялгар дэрс	0	113
	<i>Chenopodium album</i> L.	Цагаан лууль	0	23

Бэлчээрийн ургамлан нөмрөгийн бүтэц



Бэлчээрийн тойм мэдээлэл

Хагдын хуримтлалгүй. Шоргор лууль, ширэг улалж зонхилж ургасан. Царцаа, огтоно байхгүй. Бэлчээрийн ургамлын ургалтын байдал дунд зэрэг, төв суурин газар учир хүн, машины хөдөлгөөн ихтэй, усанд автдаг, барилга байгууламжийн хог хаягдал их учраас хөрс эвдэрч унаган төрхөө алдаж байгаа, бэлчээр ашиглах боломж багассан.

Жич: Нөлөөллийн бүсийн дээд далд барилгийн болон ахуйн хог хаягдал ихтэй учраас мониторингийн цэгийг сонгох боломжгүй байсан. /Зургийг хавсаргав./

Ургамлын төлөв байдлын шинжилгээ

Бэлчээрийн төлөв байдлын ажиглалт-2023



Бэлчээрийн төлөв байдлын ажиглалтын үр дүнг гаргасан

ХААЦУ-ын технологич инженер
Хянасан: УЦУОШТөвийн дарга

Ч.Уранчимэг
[Signature]

Ч.Уранчимэг
Б.Хэрлэнчимэг

Өндөрхаан тохижилт үйлчилгээний газартай байгуулсан хог хаягдал тээвэрлэх гэрээ

БАТЛАВ.
"ӨНДӨРХААН ТОХИЖИЛТЫН ГАЗАР" ОНТҮГ-Н
ЗАХИРАЛ *О. Гомбобаатар* О. ГОМБОБААТАР

ХОГ ХАЯГДЛЫН ТУХАЙ АЖ АХУЙН ГЭРЭЭ

2023 оны *08*-р сарын
08-ны өдөр

№ *15*

Чингис хот

НЭГ: ЗОРИЛГО

Энэхүү гэрээний зорилго нь аж ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг цуглуулах, хадгалах, тээвэрлэх талаар нэг талаас гүйцэтгэгч гэх "ӨНДӨРХААН ТОХИЖИЛТЫН ГАЗАР" ОНТҮГ /цаашид гүйцэтгэгч гэх/ нөгөө талаас захиалагч болох /ХАСУ МЕГАВАТТ ХХК/ цаашид захиалагч гэх/ -ийн хооронд үүсэх эрх зүйн болон санхүүгийн харилцааг зохицуулахад оршино.

Энэхүү гэрээ нь хоёр этгээдийн эрх бүхий албан тушаалтан баталсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж мөрдөгдөнө.

ХОЁР: ГҮЙЦЭТГЭГЧ БАЙГУУЛЛАГЫН ЭРХ, ҮҮРЭГ

1. Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалахтай холбогдсон хууль, дүрэм, стандартын шаардлагыг ханган ажиллана.
2. Хог хаягдлыг тээвэрлэх аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан битүүмжилсэн тээврийн хэрэгслээр тогтоосон чиглэлийн дагуу тээвэрлэх.
3. Хог хаягдлыг дарж булшлахтай холбогдсон хууль, дүрэм журам, стандартын шаардлагыг ханган ажиллана.
4. Шаардлагатай тохиолдолд захиалагчийн дуудлагаар нэмэлт үйлчилгээ хийж хог хаягдлыг буцлах.
5. Хэнтий аймаг иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 04 дугаар "хог хаягдал тээвэрлэх зардал, үйлчилгээний хэмжээг тогтоох тухай" тогтоолын дагуу хураамж төлөх.
6. Гэрээний хугацаа 2023 оны 06 сарын 08-с 2023 оны 12 сарын 31.

ГУРАВ: ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

1. Эрхлэн байгаа үйлдвэрлэл үйлчилгээний улмаар үүсэж байгаа хог хаягдлыг хог хаягдал хадгалах түр цэгт хаях.
2. Хог хаягдлыг тээвэрлэх аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан битүүмжилсэн тээврийн хэрэгслээр тогтоосон чиглэлийн дагуу тээвэрлэх.